

## БАЙГАЛИЙН ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ БОЛОХ ЗУДЫН ҮЕИЙН БОЛОВСРОЛ-СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Ганболдын Бүрэнжаргал<sup>1</sup>

<sup>1</sup> Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын хөгжлийн ирээдүйн судалгааны сектор,

### Өгүүллийн мэдээлэл

#### Түүх:

Хүлээн авсан: 2023.07.18  
Засаж сайжруулсан:  
2023.08.28  
Хэвлэхийг зөвшөөрсөн:  
2023.09.05

#### Түлхүүр үг:

онцгой байдал, гамшиг,  
боловсрол, алслагдсан сум,  
баг

#### Холбоо барих зохиогч:

Г.Бүрэнжаргал  
Боловсролын судалгааны  
үндэсний хүрээлэн,  
Боловсролын хөгжлийн  
ирээдүйн судалгааны сектор  
Email: [burenjargal@mnier.mn](mailto:burenjargal@mnier.mn)

### Хураангуй

Монгол Улс бол хоёрхон сар үргэлжилдэг дулааны улирал богино, 45 хэм хүртэл хүйтэрдэг урт өвлийн улиралтай дэлхийн хамгийн хатуу ширүүн уур амьсгалтай орнуудын нэг юм.

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн, аймаг, сумдад цас их орсон зудын нөхцөлд малчин өрхийн ачаалал эрс нэмэгдсэнээр өрхийн бүх гишүүд мал аж ахуйн ажилд дайчлагдахтай холбоотойгоор малчдын хүүхдүүд хичээлээ хийх завгүй байдаг.

Зудын нөхцөлд мал ихээр хорогдож өрхийн амьжиргаа доошилдоогоос малчдын сэтгэл зүй хүнд, энэ нөхцөлд хүүхдийнхээ хичээл сурлагад анхаарах боломж малчин эцэг, эхийн хувьд бага байдаг. Энэ өгүүлэлд гамшиг, онцгой байдлын үеийн хуулийн зохицуулалтад шинжилгээ хийх, Байгалийн гамшиг зудын үед сурагчдын хичээлийн ирц эрс буурдаг шалтгаан нөхцөлийг илрүүлэх, сургуулийн барилга болон дотуур байрны халаалтын систем доголдох, паар хөлдөх, анги танхим хүйтэн болох, ундны ус хомсдох гэх мэт эвдрэл, доголдол гарах зэрэг эрсдэлд сургууль хэрхэн бэлэн байдаг талаар тодруулахыг зорив. Сургуулийн удирдлагын зүгээс энэхүү эрсдэлийг хэрхэн даван туулсан болон урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авсан байдлыг тодруулах зэрэг болно.

### Education during natural disaster dzud - survey results

#### Authors:

Burenjargal, G  
Mongolian National Institute  
for Educational Research

#### Keywords:

emergency, disaster,  
education, remote area,  
student

### Abstract

Mongolia is one of the countries with the harshest climate in the world, with a short warm season lasting only two months and a long winter with temperatures below 35-40°C.

Due to the severe winter and spring climate, heavy snowfall in the provinces and soums, the workload of herding families increases dramatically, and herders' children are engaged in animal husbandry because of everyday busy schedule.

When herders experience severe weather conditions and heavy snowfall, the number of livestock reduce drastically, their family livelihood decreases, which negatively affect their psychological state, pay less attention to their children's schooling.

In this article we analyzed the legal regulations on disasters and emergencies, we aimed to clarify secondary schools' preparedness to the risks such as, drastic drop in attendance of students during natural disasters, failure of the heating system of school buildings and dormitories, cold classrooms, shortage of drinking water, etc.

## УДИРТГАЛ

Дэлхийн байгаль цаг уурын хувьсан өөрчлөлт, байгальтай зүй бус харилцаж буй хүний зохисгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдлийн давтамж 1970-аад оноос хойш улам нэмэгдэх болсныг НҮБ-ын төрөлжсөн байгууллагаас анхааруулсаар байна. Монгол Улсын хувьд сүүлийн 60 жилд Монгол орны агаарын жилийн дундаж температур 1.56 градусаар нэмэгдэж, ган, зуд, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж ойртсоныг судлаачид тэмдэглэжээ<sup>1</sup>.

Монгол Улс бол Зүүн хойд Азид оршдог хуурай газраар хүрээлэгдсэн, газар нутгийн хувьд хойд хэсгээрээ өндөр уулс нуруудын тогтолцоотой, өмнөд хэсгээрээ уудам тал, цөл нутагтай. Монгол орны эрс тэс уур амьсгал тэр дундаа өвөл агаарын температур буурч, хүйтний эрч чангарч, их хэмжээний цас үргэлжлэн орсноор зудын нөхцөл байдалд ордог. Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс зуны ган, зуншлага өвөл хаврын бэлчээрийн даац, бэлчээрийн ургац, малын тоо, агаарын температур, хур тунадасны дундажтай харьцуулсан хазайлт, цасны бүрхэц, зузаан болон агаарын температур, хур тунадасны төлөв зэрэг мэдээллийг ашиглан зудын эрсдэлийг тодорхойлдог байна. Энэ нь иргэд, төр засгийн байгууллагуудын зүгээс зудын үед авах хариу арга хэмжээг боловсруулахад чухал мэдээлэл болдог. Зуд нь боловсролын салбар түүний дотор хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээл учруулдаг. Тухайлбал, энэ үед зам, даваа хаагдсанаас сурагчид болон багш, ажилтан сургуульдаа ирэх буцахад хүндрэлтэй болдог төдийгүй хүн бүл дутсанаас дунд, ахлах ангийн хүүхдүүд сургуульдаа явахаас илүүтэйгээр гэр бүлтэйгээ хамт байж мал маллах ажилд туслах хэрэгтэй болдог. Үүнээс үүдэн малчин өрхийн хүүхдүүд хичээл таслах, хоцрогдох нөхцөл байдал үүсдэг. Энэ байдлыг хэд хэдэн судалгаагаар тогтоосон байдаг боловч хичээл тасалж, хоцрогдох эрсдэлд орсон хүүхдүүдэд үзүүлэх дэмжлэг, зохион байгуулалтын талаар цаашид судлах хэрэгцээ байна.

## СУДЛАГДСАН БАЙДАЛ

Монгол улсын цаг уурын эрс тэс уур амьсгалын нөлөөлөл боловсролын салбарт хэрхэн нөлөөлж буй байдлыг судалж үзэхэд арван нэгдүгээр сараас хоёрдугаар сар хүртэл үргэлжлэх зудын хүндрэл нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад шууд нөлөө үзүүлдэг байна.

1999-2002 болон 2009-2010 оны зудын үеэр хэт хүйтэн агаарын хэмээс шалтгаалан сургууль, дотуур байрны халаалт, хүнсний хангалтад хүндрэл учирч байсан (Lawrie and Dandii 2010; United Nationals 2000).

Цас хэт их орж, цаг агаар цочир хүйтэрснээр сурагчдын сургууль завсардалт нэмэгддэг төдийгүй өрхийн амьжиргаа болон эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй. Зудын үеэр малын тоо ихээр хорогдсоны улмаас өрхийн орлого буурч, эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсролд зарцуулах зардлыг хариуцах чадамжгүй болдог (БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, 2019).

1999-2002 он, 2009-2010 онд болсон зудын хоёр тохиолдлын нөлөөг судалсан судалгаанаас үзэхэд зудын улмаас Монгол орны баруун хэсэгт малчин өрхийн хүүхдийн суурь боловсролд хамрагдалт буурч байсан бол малчин бус гэр бүлд энэ байдал ажиглагдаагүй байна. Энэ байдал сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд хамгийн ихээр ажиглагдсан байна (БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, 2019). 2009-2010 онд болсон зудын үеэр сургуулийн 40 хувь, цэцэрлэгийн 50 хувьд нь хүүхдийн ирц буурсан бөгөөд зудад хамгийн

<sup>1</sup> <https://montsame.mn/mn/read/274009>

ихээр өртсөн орон нутагт сургууль завсардалт, хичээл таслалт илүү ихээр бүртгэгдсэн байна (Лори, Д.Одгэрэл, 2010).

Их хэмжээний цас орсны улмаас сургуулийн дээвэр, хананд гэмтэл үүсэх, сургууль руу зорчих зам нэлээд хүндрэлтэй болдог. Үүний зэрэгцээ хэт хүйтэн агаарын хэм нь сургууль, дотуур байрны халаалт доголдох, хоол, хүнсний хангамж хомсдох бэрхшээл учруулж болзошгүйг 2009-2010 онд болсон зудын гамшиг харуулсан (Лори, Д.Одгэрэл, 2010). Мөн зудын үеэр сургуулийг түр хугацаагаар хаах нь элбэг байдаг. Тухайлбал, 2009-2010 онд болсон зудын үеэр сургуулиудын 35 хувь нь 1-5 хүртэл хоног, 12 хувь нь 6-аас дээш хоногоор тус тус хаагдсан байна (Лори, Д.Одгэрэл, 2010). Үүнээс гадна сургуулиудын гуравны хоёроос илүү нь 8-аас дээш анги танхимыг ашиглах боломжгүй болж хаасан (*цасан шуурга, хүчтэй салхи дээврийг хийсгэн эвдэх, халаалтын зуух эвдрэх, дулааны шугам, труба хөлдсөний улмаас хагарах гэх мэт*) (Лори, Д.Одгэрэл, 2010).

2023 оны өвөл улсын хэмжээнд 12 аймгийн 37 сум цагаан зудархуу байдалд өвөлжсөн байх бөгөөд эдгээр сумдад сургуулийн насны 7000 гаруй хүүхэд байгаагаас 2200 орчим нь зудад өртсөн малчин өрхийн хүүхдүүд байна гэсэн урьдчилсан тоон мэдээ гарчээ (ҮСХ,2023).

## АРГА ЗҮЙ

Судалгаанд тоон болон чанарын шинжилгээний арга ашигласан бөгөөд тоон мэдээлэл болох асуулга судалгааг цахимаар болон биечлэн цуглуулав. Асуулга судалгаагаар сонгосон аймаг, сумдын сургуулиуд 2023 оны зудын үед хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд гарсан хүндрэл, бэрхшээл түүнийг шийдвэрлэх арга замыг судалгаанд оролцогчдын саналд тулгуурлан илрүүлэхийг оролдсон болно.

Чанарын шинжилгээг эрх зүйн болон бодлогын баримт бичгийн агуулгад хийлээ. Шинжилгээгээр байгалийн гамшигт үзэгдлийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг авч үзэв.

### *Асуулгын шинжилгээ*

2022-2023 оны ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн хугацаанд зудтай хэмээн бүртгэгдсэн 12 аймгийн 37 сумаас жил бүр хамгийн их цас унадаг аймаг болох Баянхонгор, Ховд, Баян-Өлгий, Хэнтий аймгийн алслагдсан 19 сумын сургуулийг сонгож, сургуулийн захирал, менежер, нийгмийн ажилтнуудыг хамруулсан.

Анхдагч мэдээллийг боловсруулахдаа IBM SPSS Statistics 26.0 программаар нэгтгэн, асуулга тус бүрд хариулсан байдалд холбогдох фактор болон хүчин зүйлийн шинжилгээнүүдийг хийв.

### *Баримт бичгийн шинжилгээ*

Байгалийн гамшигт үзэгдлийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодруулах үүднээс зарим хууль тогтоомжид агуулгын шинжилгээ хийв. Үүнд:

- Боловсролын тухай хууль (2002 он)
- Бага, дунд боловсролын тухай хууль (2002 он)
- Хүүхэд хамгааллын тухай хууль (1996 он)
- Гамшгийн тухай хууль (2003 он)

- Ковидын тухай хууль (2020 он)

**НЭГ. БАРИМТ БИЧГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЭХНИЙ ҮР ДҮН**

Баримт бичгийн шинжилгээг байгалийн гамшигт үзэгдлийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг дараах 3 үзүүлэлтийн хүрээнд авч үзсэн. Үүнд:

1. Гамшгийн өмнө
2. Гамшгийн үед
3. Гамшгийн дараа

Хүснэгт 1. Хуулинд тусгагдсан хичээл сургалтын үйл ажиллагаа

№	Үзүүлэлт	Хуульд тусгагдсан үйл ажиллагааны заалт	Эх сурвалж
1	Гамшгийн өмнө	- Сургалтын хөтөлбөрт гамшгийг бууруулах, дасан зохицох, нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх талаар тусгах	- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3-р бүлгийн 3.6-р зүйлийн 4-р заалт
2	Гамшгийн үед	- Хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоох - Хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах - Цахим сургалтын тогтолцоог бий болгох - Гамшгийн үед сурагчдыг дайчлах	- Боловсролын тухай хуулийн 4-р бүлгийн 28-р зүйлийн 28 <sup>2</sup> .1.3 заалт - Хүүхэд хамгааллын тухай хуулийн 1-р бүлгийн 1-зүйлийн 1.1 заалт - Ковидын тухай хуулийн 2-р бүлгийн 7-р зүйлийн 7.1.8 болон 7.1.9-р заалт - Гамшгийн тухай хуулийн 2-р бүлгийн 10-р зүйлийн 10.4.7
3	Гамшгийн дараа	Гамшгийн дараах боловсролд үзүүлэх хор уршгийг арилгах талаар хуулийн зохицуулалт одоогоор байхгүй байна.	


Онцгой байдал, гамшигт үзэгдлийн үед хичээл сургалтын үйл ажиллагааг түр зогсоох, сургалтын хэлбэрийг өөрчлөх талаар хуульд заасан хэдий ч зайнаас, теле болон цахимаар хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй олгох зохицуулалт Ковидын тухай хуулиас бусад хуульд тусгагдаагүй байна. Ковидын үед хэрэгжиж байсан зарим хуулийн зохицуулалт хүчингүй болсон байна.

**ХОЁР. АСУУЛГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Байгалийн гамшиг зудтай хэмээн бүртгэгдсэн 12 аймгаас судалгаанд 4 аймгийн алслагдсан 19 сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан хамруулан мэдээлэл цуглуулав.


Судалгаанд хамрагдсан сумдын сургуулийн удирдлагуудаас сурагчдын хичээлийн ирцийн мэдээлэл авч түүн дээрээ тулгуурлан шинжилгээ хийж үзэхэд малчин өрхийн сурагчид нэгдүгээр улирлын амралтын (2022.12-2023.2 дугаар сарын хооронд) дараа болон үндэсний баяр ёслол тэр дундаа 2-р сарын дунд үеэр тохиодог Цагаан сарын баярын амралтын өмнө болон хойно, мөн цас онцгой их хэмжээгээр орсон үед сурагчдын хичээлийн ирц буурдаг байна.

Зураг 3. Хичээлийн ирц, бага, дунд, ахлах анги (хувиар)



Дунд, ахлах ангийн сурагчдын хувьд хичээл тасалт бага ангийн сурагчидтай харьцуулахад өндөр байгаа нь энэ насны сурагчид ар гэрийн нөхцөл байдлаас болж хичээлээ тасалдаг ингэхдээ 1-2 долоо хоног, 3-7 хоногийн чөлөө хүсдэг байна. Мөн эд хүйтний үед сурагчдын дунд томуу, томуу төст өвчлөл нэмэгддэг тул энэ үед мөн сурагчдын ирц буурдаг байна.


Зураг 4. Хичээлдээ ирэхгүй байгаа шалтгаан, нөхцөл (хувиар)



Сурагчид олон хоногоор хичээлдээ ирэхгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодруулсан (Зураг 4) мэдээллээс үзэхэд “гэр бүлдээ туслах” нь хамгийн их хувийг эзэлж байгаа бол 15 орчим хувь нь зам даваа хаагдах, унаагүй болох зэрэг байна.

Үүний зэрэгцээ цөөн боловч хувь нь сурлагын хоцрогдолтой, сурах сонирхолгүйгээс хичээлдээ ирдэггүй нь анхаарал татаж байна. Энэхүү шалтгаан нь тухайн сурагчдыг сургуулиас завсардахад хүргэх үр дагавартай болохыг анхаарах хэрэгтэй юм.

Зураг 5. Зуд нь сургалтын үйл ажиллагаанд нөлөөлсөн нөлөөлөл (хувиар)



Судалгаанд хамрагдсан сургуулиуд зудын үед хичээл сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явуулж байсан хэдий ч сурагчдын хичээл сургалтад сөрөг үр дагавар үзүүлсэн нь Зураг 5-аас харагдаж байна. Үүнд хамгийн их хувийг сурлага, хүмүүжил өөрчлөгдөх болон эцэг, эхийн хараа хяналт суларсан үр дагавар эзэлж байна.

Өвлийн цочир хүйтэнд тав тухгүй орчинд суралцагчид хичээллэх нь хичээлд анхаарах анхаарал сулрах, хичээлээ ойлгохгүй байх зэрэг асуудал үүсдэг бөгөөд үүнд эцэг эх, хүүхдүүддээ тавих хараа хяналт сулардаг нь ч нөлөөлдөг байх талтай.

Зураг 6. Зудын дараа сургуульдаа буцаж ирсэн сурагчид (хувиар)



Судалгаанд хамрагдсан малчин өрхийн сурагчид зудын үед олон хоног хичээл тасалсан болон өвчтэй байсан хэдий ч эргэж сургуульдаа ирсэн сурагчдын 80 орчим хувь нь сургалтын агуулгаас хоцорсны улмаас сурлагын хоцрогдолд орох, хичээлийн идэвх сулрах эрсдэлтэй байдаг гэж судалгаанд оролцогчид үзсэн байна.

Зудын үед хичээлдээ ирэхгүй байгаа сурагчдад багш нар тодорхой арга хэмжээ авдаг байна. Тухайлбал;

- Сурагчид хичээлдээ суухдаа тухайн агуулгыг нөхөж гүйцэт судалж чаддаггүй. Иймээс багш нар нэмэлт цагаар давтлага өгөх шаардлага гардаг.
- Багш нар дотуур байранд нь очиж хичээл сургалтын үйл ажиллагааг явуулж байв.


Зарим багш нарын хувьд хол отроор нүүсэн малчин өрхийн сурагчидтай сүлжээ байхгүйн улмаас гэрийн даалгавар өгөх, харилцаа холбоо тогтоож чадахгүй тохиолдлууд гарч байжээ.

Зураг 7. Багш нарын сурагчдадаа авсан арга хэмжээ (хувиар)



Зураг 7-оос харахад багш нарын 50 гаран хувь нь сурагчдадаа хүрч ажиллахыг эрмэлзсэн байх боловч мэдээлэл өгсөн багш нарын 3/1 нь ямар ч арга хэмжээ аваагүй байгаа нь санаа зовоох үзүүлэлт байна.

Зураг 8. Тодорхой хугацаагаар хичээлдээ ирээгүй сурагчид багш нараасаа хүсдэг зүйл (хувиар)



Тодорхой хугацаагаар хичээлдээ ирээгүй сурагчдын 80 гаруй хувь нь сургуульдаа эргэж ирээд анги хамт олонтойгоо хоцорсон хичээлээ нөхөж авахыг хичээдэг байна.

Харин бага, дунд ангийн сурагчид ангийн сурагчдаасаа гэрэвших, багш яах бол гэсэн айдас түгшүүртэй болдог гэж

судалгаанд оролцогчид хариулж байсан.

Шинжилгээнээс харахад зудын үед олон хоног хичээлдээ ирж чадаагүй хүүхдүүд дараах хүндрэл бэрхшээлтэй тулгардаг байна. Үүнд:

Сэтгэл зүйн хувьд:

- Ар гэртээ санаа зовох, удаан хугацаагаар гэр бүлтэйгээ холбоо барихгүй байх байдал нь анхаарал төвлөрөл буурах
- Багш нар болон ангийн нөхдөөсөө санаа зовох,
- Багш нараасаа айж түгших
- Бусадтай найзалж нөхөрлөхдөө бэрхшээх
- Зожиг ганцаардмал болох

- Хүүхэд, багш анги хамт олонтойгоо харилцах сонирхолгүй болох  
Суралцахуйн хувьд:

- Хичээл сургалтын үйл ажиллагаанд оролцох идэвх сулрах
- Сургалтын агуулгаас хоцрох улмаар суралцахуйн хоцрогдолд орох
- Олон хоногийн хичээл нөхөж авах, цаашид суралцах зориг мохох, шантрах
- Сурах нь бэрхшээлтэй санагдах
- Хичээлдээ идэвх зүтгэл гаргахгүй
- Олон нийтийн үйл ажиллагаанаас зайлсхийх,

Судалгаанд оролцогчдоос зуд дахин тохиолдвол ямар арга хэмжээ авах талаар тодруулахад багш-эцэг эх-сурагчдын эргэх холбоог сайжруулах, цахим сургалтыг хичээл сургалтад нэвтрүүлэх шаардлагатай гэж 81 хувь нь хариулсан байна. Сургуулийн удирдлагуудын хэлж байгаагаар зудын үед багш нарын 75 хувь нь сэтгэл зүйн хямралд ордог гэсэн байна. Зудын үед сургуульдаа ирэхгүй байгаа сурагчдын эцэг эхтэй харилцахад багш нарт хүндрэл үүсэх, багш нар өөрсдөө өвдөх, сургуульд ирж очих зам, даваа хаагдах зэрэг бэрхшээлүүд тулгардаг байна. Мөн мал малладаг багш нарын хувьд энэ үед ажлын ачаалал давхар нэмэгддэг тул дийлэнх нь стресст ордог байна.

Багш нар зудын дараа хэрэгжүүлж болохуйц дараах саналуудыг дэвшүүлсэн. Үүнд:

***Хичээлдээ ирэхгүй байгаа сурагчдад зориулсан арга хэмжээ***

- Сурагчид эцэг эхтэй эргэх холбоог сайжруулах зайны хөтөлбөртэй болох
- Цахим сургалтыг, хичээл сургалтад нэвтрүүлэх, багш сурагч эргэх холбоотой ажиллах
- Зудын нөхцөл байдал үүссэн үед сурагчдын сурлагын түвшин тогтоож сурагч бүрийн онцлогт тохирсон даалгавар өгөх, ганцаарчлан ажиллах

***Суралцаж буй сурагчдад зориулсан арга хэмжээ***


- Багш, сурагчдаас зудын нөхцөл байдлын судалгаа авч түүний мөрөөр ажил төлөвлөн явуулах, сурагчдын амралтыг сургагч багш, малчдын санал дээр тулгуурлан зохион байгуулах
- Хичээл завсардсан сурагчдын үнэлгээ дээр арга зүйг боловсруулах
- Сурлагын хоцрогдлыг арилгах аль болох сургалтын үйл ажиллагаанд хамруулах

***Цаашид хэрэгжүүлж болох санал***

- Нэгдүгээр улирлын амралтын хугацааг багасгаж, мал төллөх үеийн амралтыг уртасгах
- Хавар нүүх, мал төллөх үед хүүхдүүд аав ээжийнхээ дэргэд удаан байх шаардлагатай байдаг тул сурагчдын амралтыг 4 улирлаар хичээллүүлэх



### Судалгаанд хамрагдсан сургуулиудын хичээлийн байрны өнөөгийн нөхцөл байдал



уурын зуух хөлдөж, сургуулийн барилга, дотуур байр халаалтгүй болж зогсох эрсдэл үүсдэг гэсэн хариултуудыг өгсөн. Харин цөөн хувь нь сургуулийн орчин нөхцөл сайн гэж хариулсан байна.

Зураг 9. ЕБС-ийн өнөөгийн нөхцөл байдал, хувиар

Аймгийн төв, сумаас алслагдсан сургуулиудын 95 орчим хувь нь сургуулийн барилга хуучирсан үүнээс улбаалан цаг агаар эрс хүйтрэхэд анги танхим хүйтэн, анх баригдсан үеийн цонхтой болохоор салхи шороо орж ирдэг, цонхноосоо сийгдэг, дулаан алдалттай, хүн суухын аргагүй хүйтэн болдог. Мөн энэ үеүдэд

### Сургуулийн бэлэн байдал, төлөвлөлт, зохион байгуулалт

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 80 хувьд нь гэнэтийн аюул ослын үед ашиглах бэлэн байдлын төлөвлөгөө байдаггүй. Харин 20 хувь нь Байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед төлөвлөгөө гаргаж ажилладаг. Цөөн сургууль дээр цар тахлын үед боловсруулсан төлөвлөгөөтэй байв.

Сургуулийн удирдлагууд байгалийн гамшигт үзэгдлийн үед малчин өрхийн сурагчдад зориулсан цахим хичээл, гэрийн даалгаврын сантай болох, багш, сурагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлдэг байх, сурагчдын эрүүл аюулгүй байдлыг хангах, орчин бүрдүүлэх, эцэг эхтэй эргэх холбоотой ажиллах гарын авлагатай болох зэргийг тусгасан төлөвлөгөө гаргах шаардлагатай гэж үзэв. Тухайлбал:

- Сурагчдыг хичээл таслуулахгүй байх тал дээр эцэг эх, асран хамгаалагчтай хамтарч ажиллах (*цахим хичээл контентуудыг малчдын хүүхдүүдэд хүргэх арга замыг эрэлхийлэх*);
- Зудын үед хичээл сургалтын үйл ажиллагаанаас хоцорсон сурагчидтай ажиллах тусгай төлөвлөгөө гаргаж ажиллахад эцэг эх, асран хамгаалагчтай хамтарч ажиллах;
- Сурагчдын амралтыг аймаг өөрөө зохицуулж хагас сайн өдөр хичээллүүлж амралтын хугацааг уртасгах боломжоор хангах (*мал төллөх үеэр эцэг эхчүүдэд хүүхдийн тусламж хэрэгтэй болдог*);
- Багш, эцэг эхчүүдэд дэмжлэг болохуйц үе шаттай сургалтууд зохион байгуулах;
- Хөдөө алслагдсан айл өрхүүдтэй холбоо тогтоох сүлжээ тоног төхөөрөмжтэй болгох тал дээр орон нутаг дэмжлэг үзүүлэх, туслах;
- Орон нутаг хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх нөхцөл боломжоор хангаж, онцгой байдлын үед ашиглах хэрэглэгдэхүүний нөөцөөр сургуулиудыг хангах;

## ДҮГНЭЛТ

1. Гамшигт үзэгдлийн үе болон онцгой нөхцөл байдал үүсэж хөл хорио тогтоосон үед сурагчдын хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх бодлого зохицуулалт ковидын хуулиас өөр хуулиудад тусгагдаагүй байна. Ковидын хуульд тусгагдсан зарим зүйл, заалтууд гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хэрэгжүүлж болохуйц байсан хэдий ч заалтуудыг хүчингүй болгосон байна. Иймээс онцгой нөхцөл байдал үүсэн тохиолдолд ашиглаж болохуйц хуультай болох шаардлагатай байна.
2. Байгалийн гамшигт үзэгдлийн үед сургуулиудад хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх хөтөлбөр төлөвлөгөө байдаггүй гэнэтийн аюулын үед бэлтгэлгүй байдаг нь дээрх судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иймээс тухайн орон нутгийн сургуулиуд өөрсдийн байгаль цаг уурын онцлогт тохирсон гэнэтийн онцгой нөхцөл байдлын үед ашиглах боломжтой хөтөлбөр төлөвлөгөөтэй бэлтгэлтэй болох шаардлагатай байна.
3. Гэнэтийн онцгой нөхцөл байдлын үед хичээл сургалтын үйл ажиллагааг цахимаар болон теле, зайнаас зохион байгуулахад багш нарыг бэлтгэсэн байх, техник хэрэгслийн хүрэлцээ хангамжтай болох хэрэгцээтэй байна.
4. Байгалийн гамшиг тохиолдсон үед хичээл сургуульдаа ирээгүй сурагчдад зориулсан хоцорсон үеийнх нь хичээлийг багш нарт нь илүү цагийн хөлс олгон заалгах, цахим болон цаасан сургалтын материал хэвлэж өгч судлуулах.
5. Сургуулиудад орон нутгаас нь дэмжлэг, туслалцаа үзүүлдэг байх цас их орсон хүйтэн үед халаалтын системийг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, засварлах зэрэгт нэмэлт санхүүжилт олгох. Насжилт өндөртэй болон сургуулийн бус барилгад үйл ажиллагаа явуулж байгаа сургуулиудад их засвар оруулах, өргөтгөл барих нь зэрэгт дэмжлэг үзүүлдэг байх.
6. Байгалийн гамшиг зудын үед сурагчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах, суралцах болон хүүхэд хамгааллын чиглэлийн сургалтыг тогтмол явуулдаг болох шаардлагатай байна.

## НОМ ЗҮЙ

1. Lawrie, J. and Dandii, O. 2010. Report on the 2009-10 Dzud Disaster Impact on Schools, Kindergartens, Childrens and Teachers in Mongolia. Ulaanbaatar, Save the Children Japan.
2. Зудын эрсдлийн тухай ойлголтыг гүнзгийрүүлэх нь: Малын хорогдлын загвар ба зудын эмзэг байдлын олон үзүүлэлтэт индекс.
3. БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан, 2019. Боловсролд уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх нөлөөлөл.
4. НҮБХХ, Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) 2010. Зудын үндэсний тайлан 2009-2010. Улаанбаатар хот, НҮБХХ, ОБЕГ.
5. Лори, Ж., Д.Одгэрэл, О. 2010. Монгол Улсын сургууль, цэцэрлэг, хүүхэд, багш нарт 2009-2010 оны зудын гамшиг нөлөөлсөн байдлын тайлан. Улаанбаатар, Японы Хүүхдийг ивээх сан.
6. Үндэсний статистикийн хороо, 2022. Тайлан. Улаанбаатар хот.
7. Барилга хөгжлийн төв, 2020. “Нийгмийн дэд бүтцийн хангамж, хэрэгцээ, хэгийн төлөвийг боловсрол тодорхойлох” гэрээт ажлын тайлан. Улаанбаатар хот.

8. <https://montsame.mn/mn/read/274009>

#### ТАЛАРХАЛ

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж зөвлөн тусалсан БСҮХ-ийн Боловсролын Хөгжлийн Ирээдүй Судлалын Судалгааны Секторын эрхлэгч У.Туяа болон тус секторын эрдэм шинжилгээний ажилтан М.Хүрэлтогоо нарт талархал илэрхийлье.